



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улсын драмын эрдмийн театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/183/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimeg.ts@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Энхдалай

Утас:260512 Цахим хаяг:enkhdalai.d@audit.gov.mn

Аудитор: М.Ганбаатар

Утас:261885 Цахим хаяг:ganbaatar.m@audit.gov.mn

Шинэ баланс аудит ХХК-ийн захирал: Б.Мэндбаяр

Утас:99032649 Цахим хаяг: info@shinebalans-audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.29 № 07/577
танай _____-ны № _____-т

УЛСЫН ДРАМЫН ЭРДМИЙН
ТЕАТРЫН ЗАХИРАЛ
Д.ЦЭРЭНСАМБУУ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын драмын эрдмийн театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын драмын эрдмийн театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Улсын драмын эрдмийн театр нь үндэсний, орчин үеийн болон дэлхийн сонгодог шинэ уран бүтээл туурвиж, “Цахим театр төслийн хүрээнд” 2 уран бүтээлийг видео хэлбэрт 1 уран бүтээлийг аудио хэлбэрт шилжүүлсэн байна. Мөн тусгай хэрэгцээт иргэдийг оролцуулан уран бүтээлийн төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Гамлет” төслийг санаачлан гадаад болон дотоодын уран сайхны зөвлөлөөр хянуулан сайн үнэлгээтэйгээр батлуулсан.

Аудитын гол асуудал

Театрын гол тайз засвартай байгаа хэдий ч төлөвлөгөөний дагуу “Тоглоомчид”, “Гамлет”, “Хайрын виз”, “Тэнгэрийн хүү”, “Ромео Жульетта”, “Анна Каренина”, “Би ч гэсэн жаргамаар байна”, “Миний аав супер баатар” жүжгүүд амжилттай тоглогдож нийт 82 удаагийн тоглолтоор 32,150 үзэгчдэд хүргэсэн байна.

Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1 дүгээр зорилтын хүрээнд Соёлын сайдын тушаалаар “Соёлын сэргэлт” аяныг зохион байгуулах нэмэлт санхүүжилт хүлээн авсан. Үүний дагуу Увс аймгийн 19 сумаар явж 28,755 үзэгчдийг хамруулан соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Мөн Монгол улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр баталсан 241 дүгээр “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох” тогтоолын дагуу цалингийн нэмэгдлийг төсөвлөн, санхүүжилт авсан.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,066,970,194.44	1,372,438,639.41
33	АВЛАГА	466,825.00	1,400,902.02
33500	Бусад авлага	-	1,400,902.02
33510	Байгууллагаас авах авлага	-	1,400,902.02
35	БАРАА МАТЕРИАЛ	1,066,503,369.44	1,371,037,737.39
35100	Түүхий эд материал	4,767,740.00	5,621,060.00
35110	Тусгай зориулалттай материал	4,767,740.00	5,621,060.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	17,847,400.00	17,847,400.00
35400	Хангамжийн материал	1,043,888,229.44	1,347,569,277.39
35410	Бичиг хэргийн материал	690,000.00	850,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	3,000,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,043,198,229.44	1,343,719,277.39
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,191,981,926.09	6,927,791,393.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,191,981,926.09	6,927,791,393.82
39200	Биет хөрөнгө	6,753,707,926.09	6,489,517,393.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,281,224,160.00	7,281,224,160.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(965,976,460.22)	(1,201,399,399.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	441,937,000.00	441,937,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(283,228,666.81)	(329,437,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	849,916,886.86	877,698,886.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	(634,248,428.63)	(671,689,268.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	181,282,206.70	218,610,706.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(128,342,368.81)	(138,571,288.86)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	11,143,597.00	11,143,597.00
39300	Биет бус хөрөнгө	438,274,000.00	438,274,000.00
39301	Программ хангамж	2,800,000.00	2,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,800,000.00)	(2,800,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	438,274,000.00	438,274,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,258,952,120.53	8,300,230,033.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,063,375.00	596,550.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,063,375.00	596,550.00
41300	Өглөг	1,063,375.00	596,550.00
41360	Бусад өглөг	1,063,375.00	596,550.00
41361	Байгууллагад төлөх өглөг	596,550.00	596,550.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,257,888,745.53	8,299,633,483.23
51	Засгийн газрын хувь оролцоо	8,257,888,745.53	8,299,633,483.23
51100	Засгийн газрын оруулсан капитал	3,588,623,244.49	3,588,623,244.49
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	3,588,623,244.49	3,588,623,244.49
51200	Хуримтлагдсан үр дүн	(1,931,170,313.61)	(1,889,425,575.91)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,737,367,284.08)	(1,931,170,313.61)
51220	Тайлант үеийн үр дүн	(193,803,029.53)	41,744,737.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,600,435,814.65	6,600,435,814.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,258,952,120.53	8,300,230,033.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,004,713,122.89	4,023,289,027.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	360,000.00	2,300,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	360,000.00	2,300,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	2,300,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,004,353,122.89	4,020,989,027.27
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,086,567,700.00	3,089,728,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	917,581,744.89	931,260,527.27
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	136,885,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	917,581,744.89	794,374,927.27
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,198,516,152.42	3,981,544,289.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,198,516,152.42	3,981,544,289.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,928,628,033.28	3,753,595,708.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,507,227,392.76	2,215,952,340.52
210101	Үндсэн цалин	1,290,596,090.72	1,419,563,098.06
210102	Нэмэгдэл	169,078,252.98	398,223,892.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,302,751.06	220,408,000.00
210104	Урамшуулал	398,328.00	162,151,975.80
210105	Гэрээт ажлын хөлс	5,851,970.00	15,605,374.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,457,938.27	276,831,549.72
210201	Тэтгэврийн даатгал	151,143,865.98	191,561,071.73
210202	Тэтгэмжийн даатгал	9,846,341.74	22,457,335.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,782,993.07	17,609,467.83
210204	Ажилгүйдлийн даатгал	1,789,521.82	4,107,556.40
210205	Эрүүл мэндийн даатгал	17,895,215.66	41,096,118.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,179,847.68	148,480,425.69
210301	Гэрэл, цахилгаан	54,265,615.40	64,221,887.63
210302	Түлш, халаалт	37,742,111.36	55,778,999.06
210303	Цэвэр, бохир ус	29,172,120.92	28,479,539.00
2104	Хангамж, бараа материалын зардал	82,011,379.04	117,230,295.85
210401	Бичиг хэрэг	4,746,280.00	7,403,700.00
210402	Тээвэр, шатахуун	12,558,200.00	28,610,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,639,811.06	8,192,752.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,942,610.00	11,090,440.00
210408	Бараа материал акталсны зардал	33,124,477.98	61,933,403.85
2105	Нормативт зардал	-	772,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	772,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,259,890.00	103,422,377.63
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	88,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	3,330,000.00

210604	Урсгал засвар	25,259,890.00	100,004,377.63
2107	Томилолт, зочны зардал	91,945,450.00	44,620,500.00
210702	Дотоод албан томилолт	79,945,450.00	44,620,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	551,182,515.22	363,870,902.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	544,386,049.22	360,404,574.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,032,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	960,120.00	535,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	760,066.00	367,528.00
210807	Газрын төлбөр	2,576,280.00	530,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	361,363,620.31	482,415,316.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,561,100.00	52,121,230.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	100,993,054.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	337,802,520.31	329,301,032.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	269,888,119.14	227,948,581.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,450,000.00	188,794,008.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	50,484,386.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	35,849,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	69,450,000.00	102,460,022.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	200,438,119.14	39,154,573.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	194,584,403.16	39,154,573.19
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(193,803,029.53)	41,744,737.70
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(193,803,029.53)	41,744,737.70

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,046,446,957.00	4,020,989,027.27
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,046,086,957.00	4,020,989,027.27
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,086,567,700.00	3,089,728,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,086,567,700.00	3,089,728,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	958,848,754.00	931,260,527.27
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	136,885,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	958,848,754.00	794,374,927.27
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,931,111,945.00	3,958,178,527.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,931,111,945.00	3,958,178,527.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,660,757,000.86	3,730,229,946.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,507,227,392.76	2,216,725,530.22
210101	Үндсэн цалин	1,098,950,580.63	1,410,390,778.07
210102	Нэмэгдэл	233,688,404.49	397,365,129.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	96,145,219.64	219,715,424.94
210104	Урамшуулал	68,971,219.00	158,209,495.37
210105	Гэрээт ажлын хөлс	9,471,969.00	31,044,702.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,457,938.27	277,459,262.04
210201	Тэтгэврийн даатгал	133,387,663.18	193,387,347.75
210202	Тэтгэмжийн даатгал	14,545,607.88	21,258,771.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,498,725.89	17,609,467.83
210204	Ажилгүйдлийн даатгал	2,636,847.42	4,107,556.40
210205	Эрүүл мэндийн даатгал	26,389,093.90	41,096,118.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,179,847.68	148,480,425.69
210301	Гэрэл, цахилгаан	54,265,615.40	63,566,281.69
210302	Түлш, халаалт	37,742,111.36	58,993,051.00
210303	Цэвэр, бохир ус	29,172,120.92	25,921,093.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,983,321.06	81,354,792.00
210401	Бичиг хэрэг	5,136,280.00	9,165,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,358,200.00	30,510,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,639,811.06	8,885,752.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,849,030.00	32,794,040.00
2105	Нормативт зардал	4,852,000.00	17,033,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,852,000.00	17,033,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,971,590.00	149,706,305.63
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	36,580,000.00
210604	Урсгал засвар	29,971,590.00	113,126,305.63
2107	Томилолт, зочны зардал	92,980,450.00	44,620,500.00
210702	Дотоод албан томилолт	80,980,450.00	44,620,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	638,285,221.09	634,023,509.50

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	631,488,755.09	630,557,181.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,032,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	960,120.00	535,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	760,066.00	367,528.00
210807	Газрын төлбөр	2,576,280.00	530,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,819,240.00	160,826,621.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,819,240.00	56,720,767.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,105,854.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	270,354,944.14	227,948,581.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,450,000.00	188,794,008.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	50,484,386.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	35,849,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	69,450,000.00	102,460,022.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	200,904,944.14	39,154,573.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	195,051,228.16	37,944,040.05
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,853,715.98	1,210,533.14
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	115,335,012.00	62,810,500.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	115,335,012.00	62,810,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	115,335,012.00	62,810,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	115,335,012.00	62,810,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	115,335,012.00	62,810,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(115,335,012.00)	(62,810,500.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,589,196,963.73	6,631,196,459.53	(1,768,127,928.96)	8,452,265,494.30
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	30,760,644.88	30,760,644.88
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,589,196,963.73	6,631,196,459.53	(1,737,367,284.08)	8,483,026,139.18
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(30,760,644.88)	-	(30,760,644.88)
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(573,719.24)	-	-	(573,719.24)
C08	Тайлант үеийн үр дүн	-	-	(193,803,029.53)	(193,803,029.53)
C09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,588,623,244.49	6,600,435,814.65	(1,931,170,313.61)	8,257,888,745.53
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,588,623,244.49	6,600,435,814.65	(1,931,170,313.61)	8,257,888,745.53
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	41,744,737.70	41,744,737.70
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,588,623,244.49	6,600,435,814.65	(1,889,425,575.91)	8,299,633,483.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэлийн	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,089,728,500.00	3,051,784,459.95	37,944,040.05	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,089,728,500.00	3,051,784,459.95	37,944,040.05	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,963,481,200.00	2,926,279,973.95	37,201,226.05	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,231,103,300.00	2,201,725,530.22	29,377,769.78	98.7
210101	Үндсэн цалин	1,393,141,400.00	1,410,390,778.07	(17,249,378.07)	101.2
210102	Нэмэгдэл	482,851,200.00	397,365,129.71	85,486,070.29	82.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	175,092,600.00	219,715,424.94	(44,622,824.94)	125.5
210104	Урамшуулал	160,050,000.00	158,209,495.37	1,840,504.63	98.9
210105	Гэрээт ажлын хөлс	19,968,100.00	16,044,702.13	3,923,397.87	80.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	282,637,900.00	274,959,262.04	7,678,637.96	97.3
210201	Тэтгэврийн даатгал	192,193,800.00	190,887,347.75	1,306,452.25	99.3
210202	Тэтгэмжийн даатгал	22,611,000.00	21,258,771.67	1,352,228.33	94.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,088,800.00	17,609,467.83	479,332.17	97.4
210204	Ажилгүйдлийн даатгал	4,522,200.00	4,107,556.40	414,643.60	90.8
210205	Эрүүл мэндийн даатгал	45,222,100.00	41,096,118.39	4,125,981.61	90.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,656,200.00	99,656,199.69	0.31	100.0
210301	Гэрэл, цахилгаан	45,941,200.00	45,883,256.69	57,943.31	99.9
210302	Түлш, халаалт	42,062,600.00	41,924,240.00	138,360.00	99.7
210303	Цэвэр, бохир ус	11,652,400.00	11,848,703.00	(196,303.00)	101.7
2104	Хангамж, бараа материалын зардал	2,754,400.00	2,651,552.00	102,848.00	96.3
210401	Бичиг хэрэг	82,900.00	165,000.00	(82,100.00)	199.0
210402	Тээвэр, шатахуун	680,400.00	510,000.00	170,400.00	75.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,539,100.00	1,524,552.00	14,548.00	99.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	452,000.00	452,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	908,000.00	908,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	908,000.00	908,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	136,536,800.00	136,535,980.00	820.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	42,811,300.00	42,810,500.00	800.00	100.0
210602	Тавилга	20,000,000.00	20,000,000.00	-	100.0

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	36,580,000.00	36,580,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	37,145,500.00	37,145,480.00	20.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	207,417,500.00	207,384,425.00	33,075.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	203,942,300.00	203,918,097.00	24,203.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,032,700.00	2,032,700.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	535,400.00	535,400.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	376,400.00	367,528.00	8,872.00	97.6
210807	Газрын төлбөр	530,700.00	530,700.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,467,100.00	2,459,025.00	8,075.00	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,467,100.00	2,459,025.00	8,075.00	99.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,247,300.00	125,504,486.00	742,814.00	99.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	126,247,300.00	125,504,486.00	742,814.00	99.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	51,109,500.00	50,484,386.00	625,114.00	98.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,849,600.00	35,849,600.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,288,200.00	39,170,500.00	117,700.00	99.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,089,728,500.00	3,089,728,500.00	-	100.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,089,728,500.00	3,089,728,500.00	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	3,089,728,500.00	3,089,728,500.00	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	129	104	-	80.6
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	101	80	-	79.2
620003	Үйлчлэх ажилтан	27	23	-	85.1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		931,260,527.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ		931,260,527.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		866,760,472.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		15,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс		15,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,500,000.00
210201	Тэтгэврийн даатгал		2,500,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		48,824,226.00
210301	Гэрэл, цахилгаан		17,683,025.00
210302	Түлш, халаалт		17,068,811.00
210303	Цэвэр, бохир ус		14,072,390.00
2104	Хангамж, бараа материалын зардал		78,703,240.00
210401	Бичиг хэрэг		9,000,000.00
210402	Тээвэр, шатахуун		30,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		7,361,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		32,342,040.00
2105	Нормативт зардал		16,125,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		16,125,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		75,980,825.63
210604	Урсгал засвар		75,980,825.63
2107	Томилолт, зочны зардал		44,620,500.00
210702	Дотоод албан томилолт		44,620,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		426,639,084.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		426,639,084.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		158,367,596.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		54,261,742.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		104,105,854.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		64,500,055.14
2132	Бусад урсгал шилжүүлэг		63,289,522.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		63,289,522.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,210,533.14
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		1,210,533.14
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		931,260,527.27
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		931,260,527.27
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		136,885,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		794,374,927.27

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,939.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 8,939.3 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хангамж, материалыг бараа материалын дансанд орлого аваагүй, мөнгөн хөрөнгийн данснаас бараа үйлчилгээний зардалд 1,780.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд нийт 7,159.3 мянган төгрөгийг шилжүүлэн зардалд бүртгэснийг залруулж бүртгэсэн.	1	8,939.3			1	8,939.3	1	8,939.3				
Дүн	1	8,939.3			1	8,939.3	1	8,939.3				

Аудитаар нийт 8,931.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 8,931.5 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын зардлыг түүвэрлэн шалгахад 7,530.6 мянган төгрөгийн хангамжийн материалыг бараа материалын дансанд орлого авч, шаардлагатай хэмжээгээр зарцуулалгүй, бараа үйлчилгээний зардалд шууд бүртгэсэн байна.	1	7,530.6					1	7,530.6				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Байгууллагын нягтлан бодогч нь нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхдөө тоог андуурч гүйлгээ хийснээс тайлант оны эцсээр Нийгмийн даатгалын хэлтэст 1,400.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.	1	1,400.9					1	1,400.9				
Тус байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалыг түүвэрлэн тоолоход дараах зөрчил илэрлээ. Үүнд: 1. Хөрөнгийн кодчиллол байхгүйгээс ижил нэршилтэй хөрөнгийг тоолоход хүндрэлтэй, аль хөрөнгө гэдгийг нь тодорхойлох боломжгүй байна. 2. Ашиглах боломжгүй эвдэрсэн хөрөнгүүд байна. Тухайлбал: 5286-УНВ Хьюндай Старекс маркын машин. 3. Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн нийт 889,761.9 мянган төгрөгийн хөрөнгүүд байна. Үүнээс ашиглах боломжгүй нь актлан данс бүртгэлээс хасах, ашиглах боломжтой хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгэх асуудлыг шийдвэрлээгүй байна.	1	-					1	-				
Бараа материалын дэлгэрэнгүй болон товчоо тайлан, анхан шатны баримтуудыг Сангийн сайдын 100 дугаар тушаалд заасны дагуу бэлтгээгүй байна.	1	-					1	-				
Дүн	4	8,931.5					4	8,931.5				